

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> фэйсбүүк хуудсаар дамжуулан, олон нийтэд нээлттэй явууллаа.

Хурлын цаг: 15:00-17:00,

Хурлын байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын байранд, Цахим хэлбэрээр,

Хурлын дарга: Ц.Соёл-Эрдэнэ,

Хурлын нарийн бичгийн дарга: Г.Баярбаатар,

Хурлын ирц: Саналын эрх бүхий 319,083,372 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 93%,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. “Сүү” ХК-ийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2022 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,
5. Хөндлөнгийн аудитор нь 2022 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудал,
3. ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал,
4. “Сүү” ХК-ийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2022 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,
5. Хөндлөнгийн аудитор нь 2022 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Танилцуулсан нь:

Нарийн бичгийн дарга: Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон энэхүү шууд дамжуулалтыг хүлээн авч үзэж буй нийт хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын Нарийн бичгийн дарга хуралдааны дэгийг танилцуулав.

Одоо та бүхэнд “Сүү” ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
Тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийн тухай тогтоолыг уншиж, танилцуулья

**“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН
ТОГТООЛ**

2023 оны 04-р сарын 21-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийг хурлын даргад МЭДЭЭЛЭХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2023 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байсныг дурдсугай.

2. Бүртгэлийн өдрөөр “Сүү” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийн байдлаар компанийн гаргасан нийт 344,000,000 ширхэг хувьцаанаас 888,467 ширхэг халаасны хувьцааг хасч, тус хуралд саналын эрх бүхий 343,111,533 ширхэг байснаас 2023 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д 319,083,372 саналын эрхтэй, нийт 31 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 93 % болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын

Дарга: / Т.Дамдинсүрэн /

Гишүүд: / Ц.Бор-Охин /

Компанийн тухай хуульд заасны дагуу хурлын ирц бүрдсэн байх тул “Сүү” Хувьцаат Компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ийнхүү эхэлж байна.

Хурлыг нээж үг хэлнүү хэмээн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Ноён Соёл-Эрдэнэ таныг урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хурлыг нээж үг хэлэв.

Нарийн бичгийн дарга: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Ноён Соёл-Эрдэнэ танд баярлалаа.

Одоо Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Макс Группийн Ерөнхийлөгч, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга Ганбаатар хувьцаа эзэмшигчдэд хандан үг хэлнэ.

“Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга Ганбаатар: Хувьцаа эзэмшигчдэд хандан үг хэлэв.

Нарийн бичгийн дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга Ганбаатар танд баярлалаа. Одоо дэгийн дагуу хэлэлцэх эхний асуудал болох Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал байгаа. Үүнтэй холбоотой танилцуулгыг “Сүү”

Хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал ноён Болод болон санхүүгийн албаны дарга Ш.Даваалимбэ нар танилцуулна.

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Болод: Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалтай холбогдох танилцуулгыг хийв.

“Сүү” ХК-ийн Санхүүгийн албаны дарга Ш.Даваалимбэ: “Сүү” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, үнэт цаасны мэдээлэл танилцуулав.

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Болод: Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалтай холбоотойгоор бизнес ба хүний эрх, сүүний хэрэглээ, 2023 оны зорилго, зорилтыг танилцуулав.

Нарийн бичгийн дарга: Компанийн дотоод аудит, Гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын гүйцэтгэлийн шалгуур танилцуулав.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу дараагийн хэлэлцэх асуудал бол ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай байгаа.

Нарийн бичгийн дарга: “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай асуудалтай холбогдох танилцуулгыг танилцуулав.

Нарийн бичгийн дарга: Хурлын хэлэлцэх 3 дугаар асуудал бол ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудал байгаа.

Нарийн бичгийн дарга: “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай асуудалтай холбогдох танилцуулгыг танилцуулав.

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу дараагийн асуудал бол “Сүү” ХК-ийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2022 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай та бүхэнд танилцуулъя.

Нарийн бичгийн дарга: Хурлын “Сүү” ХК-ийн 2021 он, 2022 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2022 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг танилцуулав.

Нарийн бичгийн дарга: Хурлын хэлэлцэх 5 дугаар асуудал бол Хөндлөнгийн аудитор нь 2022 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх асуудал юм.

Хөндлөнгийн БДО Аудит ХХК: 2022 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэв.

Нарийн бичгийн дарга: Та бүхэнд ийнхүү хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа. Хурлын дэгийн дагуу цахим хэлбэрээр асуулт хүлээн авах үе шат эхэлж байна. Үүнтэй холбоотойгоор хурал 10 минут завсарлаж асуулт хүлээн авах бөгөөд энэхүү хугацаанд хувьцаа эзэмшигчид хурлын материалтай танилцан, зааварчилгааны дагуу асуух асуулт, саналаа цахим хэлбэрээр ирүүлнэ үү. Баярлалаа

Хурал завсарлав.

Нарийн бичгийн дарга: Дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн асуултанд хариулах үе шат эхэлж байна. Асуулт хариултын үе шатыг хурлын дарга удирдан зохион байгуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчид, хэрэглэгчид, харилцагчид идэвхитэй оролцож нилээн хэдэн асуулт ирүүлсэн байна. Эхний 2 асуултыг Болод захирлаас асууя.

1. Сүүлийн жилүүдэд та бүхэн хоршооны үйл ажиллагааг ихээхэн дэмжиж байна. Энэ тал дээр цаашид бариталж буй бодлого юу вэ?
2. Хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ гэсэн зорилго, зорилт дэвшүүлсэн. Үүнийг хүрээнд ямар ажил хийгдэх вэ?

Дараагийн асуултыг ТУЗ-ийн дарга Д.Ганбаатар захирлаас асууя

3. Сүүний хэрэглээ бусад улс орнуудтай харьцуулахад Монгол улсынх ямар байна вэ?

Маркетинг, борлуулалт хариуцсан дэд захирал Г.Пэлжидмаагаас асууя

4. Та бүхэн санхүүгийн тайландаа 2023 оны нэгдүгээр улиралд борлуулалт 50 хувь өссөн гэж танилцуулж байна аа. Цаашид 2023 онд борлуулалтаа хэрхэн төлөвлөж байна вэ?

Дараачийн 2 асуултыг Санхүүгийн албаны дарга Ш.Даваалимбээс асууя

5. Томоохон банк санхүүгийн байгууллагууд IPO хийж бусад компаниудын хувьцаа нэлээн савлагаатай байна. Та бүхэн ямар бодлого баримталж байна вэ?
6. Компанийн санхүүгийн тайлангаас харахад борлуулалтын орлого өссөн хэрнээ цэвэр ашгийн хэмжээ илт буурсан байна. Энийг юутай холбож тайлбарлах вэ?

ТУЗ-ийн гишүүн Д.Уянгалянхуа захирлаас бас асууя

7. Та бүхэн өмнөх оны хурлаар Жендерийн хороо, түүний үйл ажиллагааны тухай тайлагнаж байсан. Гэтэл энэ жилийн тайлангаараа тус хорооны тухай дурдсангүй. Энэ талаар мэдээлэл өгнө үү.

За баярлалаа, хурал үргэлжилж байна. Одоо болод захирал хариулна.

Гүйцэтгэх захирал М.Болод: хариулав

ТУЗ-ийн дарга Д.Ганбаатар: хариулав

Маркетинг, борлуулалт хариуцсан дэд захирал Г.Пэлжидмаа: хариулав

Санхүүгийн албаны дарга Ш.Даваалимбэ: Хариулав

ТУЗ-ийн гишүүн Д.Уянгалянхуа захирал: Хариулав

Нарийн бичгийн дарга: Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах ёстой байгаа. Санал хураалттай холбоотой Саналын хуудасны загвар, санал хэрхэн өгөх зааварчилгааг та бүхэнд Сүү Хувьцаат компанийн цахим веб хуудсаар дамжуулан танилцах боломжтой. Мөн энэхүү хурлын шууд дамжуулалтаар хүргүүлж байгаа. Энэхүү зааварчилгаатай та бүхэн танилцсан гэдэгт итгэлтэй байна. Дэгийн дагуу хурал 15 минут завсарлана. Завсарлагааны дараа Тооллогын комисс хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэн, гарсан тогтоолыг та бүхэнд танилцуулна.

Хурал завсарлав.

Тооллогын комиссын дарга: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар хэлэлцсэн асуудал тус бүр дээр гарсан саналын дүнг нэгтгэн, тогтоол гаргасан байгааг та бүхэнд уншиж танилцуулъя.

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн 2023 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналын эрхтэй нийт 319,083,372 ширхэг хувьцааны 99.99 % буюу 319,077,124 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлснээс 319,077,124 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчин төгөлдөрт тооцсугай.

2. Ердийн журмаар санал өгөх хувьцааны тоог 319,077,124 ширхэгээр тогтоосугай.

3. Саналын хуудсаар “Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
319,077,124	100	-	-	-	-

Саналын хуудсаар “ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай” асуудлаар нийт 16 хүн нэр дэвшсэн бөгөөд санал хураалтын дүнг танилцуулъя.

Ердийн гишүүнд нэр дэвшсэн 8 гишүүний хувьд

Нэр	ширхэг	Хувь
1. Д.Ганбаатар	319,081,173	8.33
2. Д.Цэрэнжигмэ Д	319,076,745	8.33
3. Д.Тунгалаг	319,076,745	8.33
4. Д.Уянгалянхуа	319,076,745	8.33
5. С.Сүхболд	319,076,745	8.33
6. С.Отгонжаргал	319,076,845	8.33
7. Д.Жамъян	319,076,745	8.33
8. Б.Түвшинтөгс	319,076,745	8.33
Хараат бус гишүүнд нэр дэвшсэн 8 гишүүний хувьд		
9. Н.Цэрэндорж	319,076,245	8.33
10. Г.Баяр	319,076,245	8.33
11. Б.Батзориг	319,076,245	8.33
12. Д.Давааням	319,076,245	8.33
13. Б.Ганбаяр	0	0
14. Г.Дөлгөөн	0	0
15. Р.Сувдгэрэл	2,020	0,001

16. Ж.Баттулга	0	0
----------------	---	---

Ийнхүү санал хураалтын нэгдсэн дүнгийн дагуу сонгогдсон гишүүдийг танилцуулъя

4. Саналын хуудсаар “ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

№	Батлагдсан тогтоолууд	Зөвшөөрсөн хувьцааны санал		Татгалзсан хувьцааны санал	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ	Ердийн гишүүнээр:			
		1. Д.Ганбаатар	319,081,173	8.33	
		2. Д.Цэрэнжигмэд	319,076,745	8.33	
		3. Д.Тунгалаг	319,076,745	8.33	
		4. Д.Уянгалинхуа	319,076,745	8.33	
		5. С.Сүхболд	319,076,745	8.33	
		6. С.Отгонжаргал	319,076,845	8.33	
		7. Д.Жамъян	319,076,745	8.33	
		8. Б.Түвшинтөгс	319,076,745	8.33	
		Хараат бус гишүүнээр:			
		9. Н.Цэрэндорж	319,076,745	8.33	
		10. Г.Баяр	319,076,745	8.33	
		11. Б.Батзориг	319,076,745	8.33	
		12. Д.Давааням	319,076,745	8.33	

5. Саналын хуудсаар “ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 100 % зөвшөөрсөн, - % татгалзсан, - % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
319,077,124	100	-	-	-	-

Тооллогын комиссын

дарга: / Т.Дамдинсүрэн /

Гишүүд: / Ц.Бор-Охин /

Нарийн бичгийн дарга: Тооллогын комисст баярлалаа.

Одоо Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолыг танилцуулна уу хэмээн Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга ноён Соёл-Эрдэнэ танийг тайзнаа урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолуудыг уншиж танилцуулан хурал хаасныг мэдэгдэв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



/Г.БАЯРБААТАР/

Хянасан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА:



/Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ/